

## ОХУ-ЫН “РОСНЕФТЬ” КОМПАНИЙН ТЭТГЭЛЭГ

### Хөтөлбөрийн товч танилцуулга

Оросын Холбооны Улсын М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургууль, Москвагийн Олон улсын харилцааны их сургуулийн бакалаврын сургалтад суралцах 10 оюутныг шалгаруулж, ОХУ-ын “Роснефть” компанийн тэтгэлгээр суралцуулдаг хөтөлбөр болно. Нийт 10 оюутан сургадаг.

### Нэг. Мэргэжлийн чиглэл, тавигдах шаардлага:

М.Губкины нэрэмжит Нефть, хийн их сургуульд байгалийн шинжлэх ухаан, экологи, байгаль хамгаалал, эдийн засаг, үйлдвэрлэлийн менежмент, байгууллагын менежмент, нефть, байгалийн хий, газрын тос, эрчим хүч зэрэг мэргэжлээр, Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуульд олон улсын харилцаа, эрчим хүчний дипломат бодлого, олон улсын эрх зүй, олон улсын эрчим хүчний хамтын ажиллагааны эрх зүйн дэмжлэг, олон улсын эдийн засаг ба олон улсын эрчим хүчний хамтын ажиллагаа, олон улсын бизнес ба олон улсын эрчим хүчний хамтын ажиллагаа зэрэг мэргэжлээр оюутан суралцуулна.

Эдгээр сургуульд суралцахаар шалгарсан оюутнууд араб, испани, болгар, чех, вьетнам, польш, франц хэлний аль нэгийг сонгон, мөн англи хэлийг сурах үүрэг хүлээнэ.

### Шалгуур үзүүлэлт

- **Бакалаврын хөтөлбөр (Хугацаа: 3-4 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Бакалаврын зэрэг	5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	<b>Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой.</b> <ol style="list-style-type: none"><li>1. 21 хүртэлх насны Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад оролцоно.</li><li>2. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 1 дүгээр ангид 3,0-аас дээш голч дүнтэй суралцаж байгаа;</li><li>3. ОХУ-ын их, дээд сургуулийн хэлний бэлтгэлд амжилттай суралцаж байгаа болон онц, сайн дүнтэй төгссөн;</li><li>4. Монгол Улсын орос хэлний гүнзгийрүүлсэн сургалтай болон ОХУ-тай хамтарсан ерөнхий боловсролын</li></ol>	

- сургуулийн төгсөх ангид 80 ба түүнээс дээш хувийн амжилттай суралцаж байгаа;
5. ОХУ-ын их, дээд сургуулийн Монгол дахь салбар сургуулийн орос хэлний бэлтгэлд суралцаж байгаа;

### Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Цахим бүртгэлд  
бүртгүүлэх  
(esis.edu.mn/grant),  
бичиг баримтаа  
скайнердаж оруулах,  
бүртгэлийн хураамж  
төлөх

2



Сонгон  
шалгаруулалтад  
оролцогч дараах  
шалгалтыг өгнө:

- Москвагийн Олон  
улсын харилцааны  
дээд сургуульд
- Орос хэл – дүрэм,  
орчуулга, сонсгол,  
эссэ (бүх бүртгүүлэгч)
- Нийгмийн тухай  
мэдлэг – тест (орос  
хэлний шалгалтад  
тэнцсэн тохиолдолд)
- Ярилцлага

3



-М.Губкины нэрэмжит  
Нефть, хийн их  
сургуульд

- Орос хэл – дүрэм,  
орчуулга, сонсгол, эссэ  
(бүх бүртгүүлэгч)
- Хими, Математик  
(инженерийн чиглэлээр  
суралцахаар  
бүртгүүлэгч, орос  
хэлний шалгалтад  
тэнцсэн тохиолдолд)
- Ярилцлага (хими,  
математикийн  
шалгалтад тэнцсэн  
тохиолдолд)



Тэнцсэн оюутан виз  
авч, ОХУ-д очих

(нийгмийн тухай  
мэдлэгийн шалгалтад  
тэнцсэн тохиолдолд)

-Шалгалтын тов, газрыг  
Боловсрол соёл,  
шинжлэх ухаан,  
спортын яам болон  
Гадаад харилцааны  
яамны цахим хуудсаар  
бүртгэлийн дараа жич  
мэдээлнэ.

**Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол**

- Бүртгэлийн асуудлаарх лавлагаа, мэдээллийг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны +51 267131 утсаар авч болно.